



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 335

Улаанбаатар хот

Дүрэмд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.12.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 3.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “МИК Актив Арван ес ТЗК” ХХК-ийн дүрмийн 1.3 дахь хэсгийг “Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол /14210/, Энхтайваны өргөн чөлөө 19, 13-р давхар” гэж өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын 1-д заасан зөвшөөрлийг олгосонтой холбогдуулан компанийн дүрэмд өөрчлөлт оруулж Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн энэ тухай Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор мэдэгдэхийг “МИК ОССК” ХХК /Б.Гантулга/-д үүрэг болгосугай.

3. Тогтоол батлагдсантай холбогдуулан хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “МИК ОССК” ХХК /Б.Гантулга/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН